



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/135

Номгон

Зарим сумдын шүлхий өвчинтэй тэмцэх  
үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27<sup>1</sup>.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2022 оны 13/01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээнд мал амьтны гоц халдварт шүлхий өвчний халдварын тархалт буурахгүй өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан тархалтыг бууруулах, тогтоох зорилгоор голомтот бүс нутгуудад ажиллаж байгаа зарим сумдын Онцгой комиссын үйл ажиллагаанд халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, бодис, уусмал, шатахууны зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэх сумдын хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Хуваарийн дагуу аймгийн Онцгой комиссоос дэмжлэг үзүүлэх шатахуун, томилолтын зардал 17,681,280 (арван долоон сая зургаан зуун наян нэгэн мянга хоёр зуун наян)-н төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д, халдвар хамгааллын хувцас хэрэгсэл, бодис, уусмалын зардал 10,950,000 (арван сая есөн зуун тавин мянга)-н төгрөгийн өртөг бүхий бараа, материалыг аймгийн Онцгой комиссын гамшгийн нөөцөөс гаргахыг Нарийн бичгийн дарга (дэд хурандаа Э.Батбаяр) нарт, нийт 33,631,280 (гучин гурван сая зургаан зуун гучин нэгэн мянга хоёр зуун наян) төгрөгийн мөнгөн болон бараа материалыг тус тус гаргахыг зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220331

Аймгийн Засаг даргын 2022 оны 03  
 дугаар сарын 10-ний өдрийн 1/135  
 дугаар захирамжийн хавсралт

**ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СУМДЫН МӨНГӨН ХӨРӨНГӨ,  
 БАРАА МАТЕРИАЛЫН ХУВААРЬ**

д/д	Сумдын нэрс	Шатахуун	Хамгаалах хувцас (мөнгөн дүн)	Бодис уусмал	Шуурхай штабын хоолны зардал	Мөнгөн дүн
1	Эрдэнэцогт	1.686.550	50 ш (950.000 төг)	-		2.636.550
2	Галуут	7.349.770	50 ш (950.000төг)	30 кг (1.050.0төг)		9.349.770
3	Баянбулаг	2.000.000	50 ш (950.000)	30 кг (1.050.0төг)		4.000.000
4	Жаргалант	2.000.000 Томилолт 756.000	50 ш (950.000төг)	30 кг (1.050.0төг)		4.756.000
5	Заг	-	50 ш (950.000төг)	30 кг (1.050.0төг)		2.000.000
6	Бөмбөгөр	-	50 ш (950.000төг)	30 кг (1.050.0төг)		2.000.000
7	Бууцагаан	-	50 ш (950.000төг)	30 кг (1.050.0төг)		2.000.000
7	Мал эмнэлгийн газар	1.632.960				1.632.960
8	Чандмань-Баянхонгор ХК				2,256,000	2,256,000
8	Шатахууны дүн	14.669.280			-	
9	Томилолтын дүн	756.000			-	
10	Бараа материалын дүн	-		10,950,000		
11	Нийт дүн					33,631,280